



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1999 оны 11 дугаар
сарын 11 өдөр

Дугаар А-236.

Улаанбаатар
хот

Ахмадын өргөө байгуулах тухай

1. Нийслэлийн ахмадын өргөөг байгуулан бүтэц орон тоог хавсралт ёсоор баталсугай.

2. Ахмадын өргөөний захиралаар Нийслэлийн ахмадын хорооны дарга Ц.Жамбааняндагийг хавсруулан ажиллуулсугай.

3. Олон улсын ахмадын жилийн ажлын хүрээнд Хотын соёлын төвийн барилгыг Ахмадын өргөө болгосонтой холбогдуулан Хотын соёлын төвийн 1999 оны үлдсэн хоёр сарын төсвийг Хотын Ахмадын өргөөнд шилжүүлэн санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/, Соёлын газар /Г.Нямсамбуу/-т тус тус зөвшөөрсүгэй.

4. Нийслэлийн Ахмадын өргөөний их засварт зориулсан 25.0 сая төгрөгийн хөрөнгөнөөс дотоод тоног төхөөрөмж засварлах, шинэчлэхэд шаардагдах хөрөнгө гаргахыг Стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Ч.Бат/, Санхүүгийн хэлтэс /Д.Гонгор/-т тус тус зөвшөөрсүгэй.

5. Олгосон хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнахыг Ахмадын өргөө /Ц.Жамбааняндаг/-нд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



Нийслэлийн засаг даргын 1999 оны
тоот захирамжийн хавсралт

**НИЙСЛЭЛИЙН АХМАДЫН ӨРГӨӨНИЙ
ОРОН ТОО**

№	Албан тушаал	Орон тоо
1	Эрхлэгч	1
2	Ня-бо, зохион байгуулагч	1
3	Жижүүр, сөнтехникч	3
4	Үйлчлэгч	2
5	Дүн	7